

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ СУМЫН НУТАГТ ШИНЭЭР ИЛРҮҮЛСЭН ТҮРЭГИЙН ҮЕИЙН ЗАРИМ ХҮН ЧУЛУУД

Ч.АМАРТҮВШИН¹, Б.БУЯН-ОРШИХ²

¹ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, e-mail: achunag@yahoo.com

²Монголын Үндэсний Музей, e-mail: bbyunorshikh@gmail.com

ТҮЛХҮҮР ҮГС: Түрэг, хүн чулуу, тахилын байгуулмж, ээмэг, бүс

ТОВЧ АГУУЛГА: Зохиогчид өгүүлэлдээ Увс аймгийн Өмнөговь сумын нутаг Бэлчирийн хоол, Дөмөөн хаварзан, Заан хамар, Пайз толгой, Тэмээн чулуу, Хавтгай сээр, Хар толгой гэсэн 7 газарт буй Түрэгийн үед холбогдох 11 хүн чулууны эх хэрэглэгдэхүүнийг багтаасан байна. Эдгээр хүн чулууд нь байршил зүйн хувьд өргөн хөндий, дэнж, өндөрлөг газарт тахилын дөрвөлжин хашилаганы дотор болон зүүн урд талд нь байрладаг ажээ. Хүн чулуудын хамгийн өндөр нь 203 см өндөртэй Тэмээн чулууны 2-р хүн чулуу, хамгийн намхан нь 50 см өндөртэй Хар толгойн 2-р хүн чулуу ажээ. Эдгээр хүн чулууд нь тойм болон бүрэн дүрслэлтэй бөгөөд Хавтгай сээрийн 2-р хүн чулуу нь хамгийн ур дүйтэй бүрэн дүрслэлтэй ажээ. Хүн чулуун хөшөөний дөрвөн тохиолдолд сахал, аяга, гурван тохиолдолд хоёр төрлийн бүс, хоёр тохиолдолд хоёр төрлийн ээмэг, нэг тохиолдолд хавтга зэргийг дүрсэлсэн байна.

Сүүлийн жилүүдэд манай орны баруун хязгаар нутаг Монгол Алтайн нуруу болон түүний салбар уулс орчимд археологийн хайгуул, малтлага судалгааны ажил эрчимтэй хийгдэж байгаа бөгөөд түүний дотор Увс аймгийн нутаг дахь түүх, археологийн дурсгалыг бүртгэн баримтжуулахад тодорхой чиглэл бүхий төсөл арга хэмжээнүүд явагдаж байна. Бид Баруун Монголын бүс нутагт хийгдэж буй археологийн өргөн цар хүрээтэй судалгаанд бага боловч нэмэр хандив болох үүднээс Увс аймгийн Өмнөговь сумын нутгаас шинээр илрүүлсэн цөөн тооны хүн чулууны тухай өгүүлж байна.


Увс аймгийн Өмнөговь сум нь тус аймгийн баруун өмнө хэсэгт орших бөгөөд урдуураа Ховд аймгийн Мянгад, баруун талаараа Баян-Өлгий аймгийн Баяннуур сумтай тус тус хиллэдэг. Далайн түвшнээс дээш дунджаар 1580 м өргөгдсөн. Газрын

гадаргын төрх байдал нь жигдбиш, хойд хэсгээрээ уулархаг, өмнөд хэсэг нь тал голдуу, төв хэсгээр өргөн тавиу, тэгш гадарга бүхий уулс хоорондын хөндий, хонхор олонтой нутаг билээ.

Анх 1989 онд Өмнөговь сумын нутагт Д.Цэвээндорж, Б.Энхбат нарын бүрэлдэхүүнтэй Увс аймгийн археологийн дурсгалын зураг зохиох шинжилгээний анги хайгуулын ажлыг зохион байгуулж нийт 23 дурсгал бүртгэсэн байдаг (Цэвээндорж, Энхбат, 2016: 335). Мөн Т.Бямбадорж, Ч.Амартүвшин нар “Увс аймгийн нутаг дахь түрэгийн үеийн зарим хүн чулууд” өгүүлэлдээ тус сумын нутгаас олдсон 4 хүн чулууны гар зураг тодорхойлолтыг нийтлүүлсэн байна (Бямбадорж, Амартүвшин, 1998). Судлаач Т.Бямбадорж “Увс аймгийн түүх соёлын дурсгалууд” хэмээх нэгэн сэдэвт бүтээлд Пайз толгойн хүн чулуудыг нийтэлжээ (Бямбадорж, 1999:

24). Мөн 2007 онд Оросын судлаач Ю.И.Ожередов Намирын голын хөндий дэх Түрэг, Монголын үеийн зарим дурсгалыг судалсан талаар эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн байна (Ожередов, 2007: 62). 2012 онд Я.Цэрэндагва, С.Далантай

нарын судлаачид Өмнөговь сумын нутаг орших Яргайт орчимд археологийн авран хамгаалах хайгуулын ажлыг гүйцэтгэж нийт 16 дурсгал бүртгэжээ (Цэрэндагва нар, 2012: 22).



Зураг 1. Увс аймгийн Өмнөговь сумын нутагт шинээр илрүүлсэн түрээгийн үеийн хүн чулууны дурсгалт газруудын байршил. 1. Бэлчирийн хоол; 2. Дөмөөн хаварзан; 3. Заан хамар; 4. Пайз толгой; 5. Тэмээн чулуу; 6. Хавтгай сээр; 7. Хар толгой

Харин тус сумын нутаг дахь хүн чулуудын судалгааны тухайд 1989 онд Д.Цэвээндорж, Д.Энхбат нар Пайз толгойн хоёр хүн чулууг бүртгэж, тодорхойлолт, гэрэл зургийн хамт тайланд тусгасан (Цэвээндорж нар, 2016:335), (Бямбадорж, Амартүвшин, 1998). Бид тус өгүүлэлд дээрх хүн чулуудын гар зураг, тодорхойлолтыг бүрэн үйлдэн нийтэлж байна.

Тус сумын нутгаас олноор буй хүн чулуудын байршил нь ойролцоогоор 70 км тойрог дотор Бэлчирийн хоол, Дөмөөн хаварзан, Заан хамар, Пайз толгой, Тэмээн чулуу, Хавтгай сээр, Хар толгой зэрэг газруудад байна (Зураг 1). Эдгээр хүн чулуудыг газрын нэрийн дагуу цагаан толгойн үсгийн дарааллаар тодорхойлж баримтжуулав.

Бэлчирийн хоолын хүн чулуу. Сумын төвөөс баруун тийш 10 гаруй км зайтай хойд өргөргийн 49° 04' 04.2", зүүн уртрагийн 91° 32' 23.8" солбицолд, Яргайт уулын зүүн

талд Бэлчирийн хоол хэмээх газар дөрвөлжин хашлаганы урд талд хүн чулууны толгой нэг ширхэг, толгой нь хугарсан хүн чулуу газарт унасан байдалтай байна.

1-р хүн чулуу. Уг хүн чулууны толгой нь үлдэж эх бие нь зөөгдөж үгүй болсон бололтой. Хүн чулууны толгой нь 45 см өндөр, 31 см өргөн 18 см зузаан. Цайвар саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. Хүн чулууны толгойны хамар, нүд хөмсөг, сахал, ам зэргийг товойлгон гаргажээ. Хоёр чихэнд ээмэг дүрсэлсэн байна. Бүрэн дүрслэлтэй.

2-р хүн чулуу. Энэхүү хүн чулууны толгой нь хугарч, эх бие нь дөрвөлжин хашлаганы өмнө талд газарт булагдаж унасан байдалтай байна. Саарал өнгийн боржин чулуугаар хийсэн. Хашлага чулууны хэмжээ 360x550 см, зүүн урагш чиглэсэн балбалтай. Хүн чулууны хэмжээ өндөр нь 63 см, өргөн нь 40 см, хугарсан толгойны хэмжээ 40 см урт, 27 см өргөн, 14 см зузаан

ажээ. Хүн чулуунд бүс дүрсэлсэн ба баруун гартаа хундага, зүүн гартаа сэлэм барьсан, бүрэн дүрслэлтэй байна.

Дөмөөн хаварзаны хүн чулуу. Энэхүү хүн чулуу нь сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнгийн хашаанд бий. Уг хүн чулууны анх байсан газарзүйн байршил нь хойд өргөргийн $48^{\circ} 51' 44.8''$, зүүн уртрагийн $91^{\circ} 18' 14.1''$ солбицолд оршино. Анх уг хүн чулуу нь 2-р багийн нутаг Ховд голын зүүн дэнж Дөмөөн хаварзан хэмээх газар байсан бөгөөд түүнийг Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын нэгэн казах иргэн зөөж явсныг Улиастай багийн засаг дарга Д.Цэрэнчимэд нарын хүмүүс зогсоож багийн төв дээр авч ирсэн байна. Хожим 2014 онд сумын төвийн цэцэрлэгт хүрээлэнд зөөвөрлөн авчирчээ. Уг хүн чулууг улаан хүрэн өнгийн чулуугаар хийсэн. Хэмжээ 75 см өндөр, 24 см зузаан, 28 см өргөн. Хүн чулуунд хүний нүүр, нүд, ам, хамар, живэр сахал, ээмэг зэргийг дүрсэлжээ. Заримдаг дүрслэлтэй.

Заан хамарын хүн чулуу. Ховд гол Улиастай багийн төвөөс баруун урагш 35 км орчим зайд том хадан хясаатай хавцлаар урсах бөгөөд нутгийхан түүнийг Доод хавцал, түүний эхэнд голынхоо зүүн дэнж дээр байх заан хэлбэрийн хадтай газрыг Заан хамар хэмээн тус тус нэрлэдэг. Энэ газарт нийт босоо болон хугарч унасан 28 хөшөө бий. Тэдгээр нь ихэвчлэн 3-7-оор бүлэглэн орших бөгөөд бүгд дөрвөлжин хашлаганаас зүүн урагш цуварсан цагариг хэлбэрийн байгууламжуудтай ажээ. Эдгээр хөшөөдийн төвд нэг эгнээнд 7 хөшөө чулуу байх бөгөөд ертөнцийн зүгээр зүүн талаас хоёр дахь нь хүн чулуу байлаа. Хүн чулууг хүрэн улаан өнгийн чулуугаар хийсэн. Хүн чулууны өндөр 180 см, өргөн 50 см, зузаан 40 см хэмжээтэй. Уг хүн чулуу хадгалалт муу бөгөөд зөвхөн нүүр, бүсний хэсэг нь тод ялгарч харагдана. Газарзүйн байршил нь хойд өргөргийн $48^{\circ} 43' 05.1''$, зүүн уртрагийн $91^{\circ} 20' 32.5''$ солбицолд орших ба заримдаг дүрслэлтэй.

Пайз толгойн хүн чулуу. Сумын төвөөс урд зүгт 20 км-т, Ховд аймаг явах замд, замаас баруун тийш 100 м зайд хойд өргөргийн $48^{\circ} 58' 42.4''$, зүүн уртрагийн $91^{\circ} 44' 28.9''$ солбицолд буюу Пайз толгой хэмээх газарт зэрэгцээ хоёр хашлага чулуунд тус бүр нэг хүн чулуу бий. Уг хүн чулууд нь тойм дүрслэлтэй ажээ.

1-р хүн чулуу. Хүн чулууг хүрэн улаан өнгийн чулуугаар хийсэн. Зүүн талын хашлага чулууны урд босоо байдалтай байна. Хэмжээ 90 см өндөр, 29 см өргөн, 20 см зузаан. Хүн чулууны нүүрийг тойм байдалтай дүрсэлжээ. Хашлага чулууны хэмжээ 440×420 см бөгөөд дотор талд хавтгай чулууг жигд дэвссэн байна.

2-р хүн чулуу. Уг хүн чулуу нь 1-р хүн чулуунаас зүүн тийш 150 м орчим зайд, дугуй хүрээтэй булшнуудын зүүн талд, 370×320 см хэмжээтэй дөрвөлжин хашлаганы урд талд байрлана. Хүрэн өнгийн чулуугаар хийсэн бөгөөд тойм дүрслэлтэй, босоо байдалтай байна. Хэмжээ 96 см өндөр, 44 см өргөн, 20 см зузаан. Хөшөөнд хамар, ам, нүд, хүзүүнд зүүлт, бүсэлхий орчимд бүсийг зөвхөн нүүрэн талд нь дүрсэлсэн байна.

Тэмээн чулууны хүн чулуу. Сумын төвөөс зүүн тийш 50 гаруй км зайтай орших Тэмээн чулуу хэмээх хадтай уулын хойд бэлд буюу хойд өргөргийн $49^{\circ} 25' 02.1''$, зүүн уртрагийн $92^{\circ} 03' 57.5''$ солбицолд оршино. Цайвар саарал өнгийн боржин чулуугаар үйлдсэн уг хүн чулуу нь дөрвөлжин хашлаганд босоо байдалтай байна. Хүн чулууны өндөр 203 см, өргөн 67 см, зузаан 40 см. Уг хөшөөнд хүний нүүр дүрслэлгүй хүзүү орчимд унжлага бүхий зүүлт эсвэл дээлний зах бололтой гурвалжин дүрс дүрслээд харин бүсэлхий хавьцаа бүтэн тойруулсан бүснээс янгирын дүрс шиг зүйл унжуулсан харагдана. Хашлага чулууны хэмжээ 120×140 см, зүүн хойд талдаа хоёр цагариган байгууламжтай. Энэхүү Тэмээн чулуу хэмээх уулын өвөр бэлээр чулуун зэвсэг, хүрэл, хүннү, түрэгийн үеийн олон

тооны дурсгалтай байдаг. Уг хүн чулуу нь тойм дүрслэлтэй.

Хавтгай сээрийн хүн чулуу. Пайз толгойн хүн чулуудаас зүүн урагш 2 км зайд, хойд өргөргийн 48° 58' 26.4", зүүн уртрагийн 91° 45' 58.1" солбицолд байрлана. Хавтгай сээрийн заагт улаан хүрэн өнгийн толгойтой, толгойгүй хоёр хүн чулуу бий. Уг хүн чулууд нь бүрэн дүрслэлтэй ажээ.

1-р хүн чулуу. Уг хүн чулуу нь дөрвөлжин хашлаганы урд талд газарт унаж эх биеийн тал нь шороонд булагдсан байдалтай байна. Хүн чулуу нь 105 см өндөр, 42 см өргөн, 20 см зузаан. Дүрслэлийн хувьд бүрэн дүрслэлтэй, нүүр, хамар, ам, живэр сахал, баруун гарт хундага, зүүн гарт сэлэм,

баруун хажууд хавтага дүрсэлсэн байна. Уг хүн чулууны бүсийг цэглэж цохих аргаар хийсэн бөгөөд нүүрэн тал болон баруун, зүүн хажуугаар тод мэдэгдэнэ. Хашлага чулууны хэмжээ нь ойролцоогоор 240x240 см.

2-р хүн чулуу. Энэхүү хүн чулуу нь толгойгүй, дөрвөлжин хашлаганы өмнө талд унасан байдалтай байна. Хүн чулууг улаан хүрэн өнгийн чулуугаар хийсэн бөгөөд баруун гартаа хундага, зүүн гартаа сэлэм барьсан, баруун хажуудаа бүснээс хавтага зүүжээ. Хэмжээ 80 см өндөр, 31 см өргөн, 20 см зузаан. Хашлага чулууны хэмжээ 240x220 см.

Хүснэгт 1. Увс аймгийн Өмнөговь сумын нутагт шинээр илрүүлсэн хүн чулуудын товч мэдээлэл

№	Газрын нэр	Дугаар	Хэмжээ (см)			Хашлага хэмжээ (см)	Солбицол
			Өндөр	Өргөн	Зузаан		
1	Бэлчирийн хоол	1	45	31	18	-	N 49°04'04.2" E 91°32'23.8"
2		2	63	40	14	360x550	
3	Дөмөөн хаварзан	1	75	28	24		N 48°51' 44.8" E 91°18'14.1"
4	Заан хамар	1	180	50	40	+	N 48°43' 05.1" E 91°20'32.5"
5	Пайз толгой	1	90	29	20	440x420	N 48°58' 42.4" E 91°44'28.9"
6		2	96	44	20	370x320	
7	Тэмээн чулуу	1	203	67	40	120x140	N 49°25'02.1" E 92°03'57.5"
8	Хавтгай сээр	1	105	42	20	240x240	N 48°58'26.4" E 91°45'58.1"
9		2	80	31	20	240x220	
10	Хар толгой	1	70	38	-	310x225	N 48°56'24.7" E 91°40'16.0"
11		2	50	30	-	235x205	

Хар толгойн хүн чулуу. Сумын төвөөс баруун урагш 15 км зайд хойд өргөргийн 48° 56' 24.7", зүүн уртрагийн 91° 40' 16.0" солбицолд буюу Алтан хөхий уулын зүүн хойд бэл Хар толгой хэмээх газар байрлана. Дөрвөлжин хашлаганы урд талд хугарч унасан, тал нь газар булагдсан хоёр хүн чулуу бий. Эдгээрийг баруун талаас нь эхэлж дугаарлав.

1-р хүн чулуу. Хүн чулууг хүрэн өнгийн боржин чулуугаар хийжээ. Хүн

чулуу нь 70 см өндөр, 38 см өргөн хэмжээтэй. Уг хүн чулууны дөрвөлжин хашлага 310x225 см хэмжээтэй. Хүн чулууг тойм байдлаар толгой, хамар, амыг зураас төдий гаргажээ. Уг хүн чулуу нь заримдаг дүрслэлтэй.

2-р хүн чулуу. Хүн чулуу нь 50 см өндөр, 30 см өргөн хэмжээтэй. Их бие нь газарт булагдсан. Баруун гартаа хундага барьж, зүүн гартаа сэлэм атгажээ. Хүн чулууны баруун талд 2 м орчим зайд толгой

нь газарт тал хэсэг нь булагдсан байх ба дүрслэл нь элэгдэж бүдгэрчээ. Дөрвөлжин

хашлаганы хэмжээ 235x205 см. Уг хүн чулуу нь бүрэн дүрслэлтэй.



Зураг 2. 1. Бэлчирийн хоолын 1-р хүн чулуу; 2. Бэлчирийн хоолын 2-р хүн чулуу; 3. Дөмөөн хаварзаны хүн чулуу; 4. Заан хамарын хүн чулуу; 5. Пайз толгойн 1-р хүн чулуу; 6. Пайз толгойн 2-р хүн чулуу; 7. Тэмээн чулууны хүн чулуу; 8. Хавтгай сээрийн 1-р хүн чулуу; 9. Хавтгай сээрийн 2-р хүн чулуу; 10. Хар толгойн 1-р хүн чулуу; 11. Хар толгойн 2-р хүн чулуу

Байршил ба дүрслэлийн онцлог

Тус сумын нутагт орших эдгээр хүн чулууд нь байршил зүйн хувьд өргөн хөндий, дэнж, өндөрлөг газар байрлана. Мөн хүн чулууд нь бүгд дөрвөлжин хашлагатай бөгөөд Тэмээн чулуу, Заан хамарын хүн чулууд хашлаганы дотор талд, харин бусад хүн чулууд нь хашлаганы зүүн урд талд байна. Хар толгой, Бэлчирийн хоол, Хавтгай сээр, Заан хамарын хүн чулууд хадгалалт муу, толгой салсан, хугарч, булгарч унажээ. Пайз толгойн хүн чулууд, Тэмээн чулууны хүн чулуудыг хавтгай чулуун дээр тойм байдлаар дүрсэлжээ. Харин бусад хүн чулууд нь бүрэн дүрслэлтэй бөгөөд хөшөөдөд хүнийг дүрслэхдээ товгор байдлаар нүүр, ам, хамар, нүд, хөмсөг, сахал болон бусад зүйлсийг тодорхой сийлсэн байна. Энэхүү дүрслэлийн арга барил нь Түрэгийн үеийн хүн чулууны өвөрмөц шинж хэмээн судлаачид үздэг (Баяр, Эрдэнэбаатар 1999:26).

Өгүүлэн буй хүн чулуудын дотор Хавтгай сээрийн хөшөөнд хавтага дүрсэлсэн байх бөгөөд энэ нь Түрэгийн үеийн хүн чулуудад түгээмэл тохиолддог дүрслэл юм. Хавтага нь нүүдэлчдийн гал гаргах хэт, цахиурын хамт хийж явах зориулалт бүхий уут савны зүйл бөгөөд Саян Алтайд малтсан Түрэгийн үеийн булшнаас биет байдлаар олдсон байдаг (Түвшинжаргал, 2013:80). Энэхүү Түрэгийн үеийн хүн чулуун хөшөөнд хавтага дүрсэлдэг хэлбэр нь хожмын Монголын үеийн чулуун хөрөгт уламжлагдан ирсэн байдаг (Баяр, 1995).

Мөн Тэмээн чулуу, Пайз толгойн 2-р хүн чулуунд “зүүлт” зүүлгэж дүрсэлсэн бололтой хүзүү, энгэр орчимд гурвалжин дүрслэл бий (Зураг 1. 6;7). Ийм маягийн хүзүүний зүүлт бүхий хүн чулуу Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Даян баатарын хөшөө (Төрбат нар, 2009: 297), Увс аймгийн Цагаанхайрхан сумын Хөшөөт, Хяргас сумын Байцын гол, Билүүгийн гол, Нийчийн амны хүн чулууд (Бямбадорж нар, 1998:119), Киргизстаны Иссык-куль нуурын орчим

зэрэг газраас олдсон байдаг (Баяр, Эрдэнэбаатар 1999: 74).

Энэхүү хүн чулуудын дотор ганц Хавтгай сээрийн хүн чулуунд дүгрэг товруутай бүс дүрсэлж (Зураг 1.9) бусад нь цулгүй бүстэй байх ажээ. Дүгрэг товруутай бүс дүрсэлсэн хүн чулууд Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын Олоннуур, Улаанхус сумын Хатуугийн ам (Баяр, Эрдэнэбаатар 1999: 160), Увс аймгийн Тариалан сумын Халхайтын дэнж, Ховд сумын Хатуугийн өвдөг, Цагаанхайрхан сумын Хөшөөтөд бүртгэгдсэн байдаг байна. Харин Алтайн Кудыргэ хэмээх газарт малтан шинжилсэн булшнаас биетээр олдож байжээ (Кубарев, 1984: 38). Дүгрэг товруутай бүс нь Төв Азийн нүүдэлчдийн дунд урт хугацаанд хадгалагдаж ирсэн бөгөөд VI зууны дунд үед согд, түрэгүүд өргөн хэрэглэж байсан төдийгүй VI-VII зууны Хятадын Сүй улсын үеийн дурсгалд ч тохиолддог байна (Төрбат нар, 2009:135).

Бэлчирийн 1-р хүн чулууны хоёр чихэнд нь дугуй цагаргины доор сэртэнтэй ээмэг дүрсэлсэн бол Дөмөөн хаварзаны хүн чулууны мөн хоёр чихэнд цагаргин ээмэг дүрсэлсэн байна. Бэлчирийн 1-р хүн чулууны ээмэг нь тухайн үеийн нүүдэлчдийн дунд түгээмэл хэрэглэгддэг ээмэг байсан бололтой. Ийм маягийн ээмэг дүрсэлсэн Түрэгийн үеийн хүн чулуу Баян-Өлгий аймгийн төв, Цэнгэл сумын Могойтын ам, Алтай сумын ОНСМ, Баяннуур сумын Загийн ам, Булган сумын Цөнхөл, Цэнгэл сумын Даян нуур (Баяр, Эрдэнэбаатар 1999), Улаанхус сумын Хар Ямаат (Төрбат 2009: 149), Архангай аймгийн Их Тамир сумын Баянцагаан, Тариат сумын Дадга (Баяр, 1997: 140) зэрэг газарт бий. Харин Уйгурын үед холбогдуулан авч үздэг Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын хүн чулуунд мөн үүнтэй төстэй ээмэг дүрсэлсэн байдаг (Баяр, Эрдэнэбаатар 1999: 123). Тухайн үед холбогдох булш оршуулга (Кубарев, 1984), хийсэн малтлага судалгаагаар ийм төрлийн ээмэгнүүд цөөн тоотой боловч олдож байжээ.

НОМ ЗҮЙ

- Баяр Д., 1995. *Монголчуудын чулуун хөрөг (XIII-XIV зуун)*. Улаанбаатар
- Баяр Д., 1997. *Монголын төв нутаг дахь хүн чулуу*. Улаанбаатар
- Баяр Д., Эрдэнэбаатар Д., 1999. *Монгол Алтайн хүн чулуун хөшөө*. Улаанбаатар
- Бямбадорж Т., 1999. Увс аймгийн түүх соёлын дурсгалууд. Улаанбаатар
- Бямбадорж Т., Амартүвшин Ч., 1998. Увс аймгийн нутаг дахь Түрэгийн үеийн зарим хүн чулууд. *Studia Archaeologica*. Том. XVII. Fasc. 1-16. Улаанбаатар
- Кубарев В.Д., 1984. *Древнетюркские изваяния Алтая*. Новосибирск.
- Ожередов Ю.И., 2007. Археолого-этнографический комплекс в Увс аймаке (Предварительное сообщение). *Монгол Алтай судлал*. № 2., Улаанбаатар.
- Төрбат Ц., Баяр Д., Цэвээндорж Д., Баттулга Ц., Баярхүү Н., Идэрхангай Т., П.Х.Жискар., 2009. *Монгол Алтайн археологийн дурсгалууд-I. Баян-Өлгий аймаг*. Улаанбаатар.
- Түвшинжаргал Т., 2013. Дундад зууны үеийн хавтага хэтний тухай. *Нүүдэлчдийн өв судлал*, Том. XV, Fasc. 1-25. Улаанбаатар.
- Цэвээндорж Д., Энхбат Б., 2016. Увс аймгийн археологийн дурсгалын зураг зохиох шинжилгээний ангийн тайлан. *Монголын археологи: Хээрийн судалгааны тайлан 1987-1989*. Боть VIII. Улаанбаатар
- Цэрэндагва Я., Далантай С., 2012. Увс аймгийн Өмнөговь сумын нутагт орших “Нутгийн хах” ХХК-ийн “Яргайт” (13138Х) дахь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хийсэн археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын тайлан. ТАХГБСХ. Улаанбаатар

РЕЗЮМЕ

НОВЫЕ НАХОДКИ КАМЕННЫХ ИЗВАЯНИЙ ТЮРКСКОГО ВРЕМЕНИ В УМНУГОВЬ СУМОНЕ УВС АЙМАКА

Ч.АМАРТУВШИН, Б.БУЯН-ОРШИХ

В статье рассмотрены материалы 11 каменных изваяний Тюркского периода, найденных в Умнуговь сумоне Увс аймака в местах Бэлчирийн хоол, Думуун хаварзан, Заан хамар, Пайз толгой, Тэмээн чулуу, Хавтгай сээр и Хар толгой. Эти каменные изваяния расположены в широкой долине, на холмах и возвышенных местах, внутри или с юго-восточной стороны прямоугольных оградок. Самая высокая статуя - второе каменное изваяние из Тэмээн чулуу, с высотой 203 см, а самая маленькая - второе каменное изваяние из Хар толгой, с высотой 50 см. Эти каменные изваяния с примитивным и полным изображением. Второе каменное изваяние из местности Хавтгай сээр самое изысканное, с полным изображением. На четырёх изваяниях изображены усы, бокалы, на трёх изваяниях - два типа поясов, на двух изваяниях - серьги и на одном изваянии - кабтака.